

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН
ТОГТОЛЦОО, ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР
ДҮН”-д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДУА-2021/14-11-ШТА-ГА

Тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон
гүйцэтгэгч Р.Мөнхтогтох
Утас: 70592439,
Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан
Аудитор Л.Уранбилэг
Аудитор Ч.Оюунтүлхүүр
Утас: 70593208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/35

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 –д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУА-2021/14-11-ШТА-ГА/ -г нэг дүгээр хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Эрүүл мэндийн газрын дарга Б.Алтантөгс нарт зөвлөсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2022 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг ахлах аудитор /Ч.Бэрхсайхан/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Р.МӨНХТОГТОХ

0012010093

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-7
	Дүрслэлийн товчёг	8-9
Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мөнхтогтох	<u>Бүлэг 1. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бодлого төлөвлөлт, эрх зүйн баримт бичгүүд болон байгууллага хоорондын уялдаа холбоо муу, үйл ажиллагаа үр дүн багатай байна.</u>	10-22
Аудитын менежер Х.Наранцаирал	1.1 Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой аймгийн бодлого, төлөвлөлт хангалтгүй, улсын хэмжээнд мөрдөгдөж буй зарим хууль, журам, стандартыг шинэчлэх шаардлагатай байна.	10-14
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	1.2 Хүнсний аюулгүй байдлыг хангах, хэрэгжүүлэх, хянах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо муу, бүтэц чиг үүрэг тодорхой бус байна.	14-15
Аудитор Ч.Оюунтүлхүүр	1.3. Аймгийн хүн ам эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой, хүртээмжтэй хангагдах баталгаа, нөхцөл бүрдээгүй байна.	15-22
Л.Уранбилэг	<u>Бүлэг 2. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой төсвөөс зариуулсан хөрөнгө хангалтгүй, төсвийн хуваарилалт үр дүн муутай байна.</u>	23-25
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	2.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сангаас хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр олгосон зээл нь орон нутгийн үйлдвэрлэлд бодитой хувь нэмэр оруулаагүй байна.	23
ХАЯГ:	2.2 Төрөөс өрхийн амьжиргааны түвшин доогуур айл өрхөд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж байгаа ч өрхийн орлогын түвшнийг харгалзахгүй, ижил хэмжээгээр олгож байгаа бөгөөд зарим өрхийн хувьд өдөрт авбал зохих илчлэг, шим тэжээлийг авч чадахааргүй байна.	24-25
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот	Дүгнэлт	26
	Зөвлөмж	27
2021 оны 11 дүгээр сар	Дээд шатны байгууллагад өгөх санал	28-30
	Санал тайлбар	31

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БЖИ	Биеийн жингийн индекс
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЖХА	Жишсэн хүн ам
МЭГ	Мал эмнэлгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
СХ	Стандарт хазайлт
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХШҮДАХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд” нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийлээ.

**Аудитын зорилго,
зорилт:**

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, орон нутагт тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, дүгнэлт зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.

Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх;
- Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй эсэх;

**Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:**

Аудитад дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Хүнсний тухай хууль;
- ✓ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль;
- ✓ Органик хүнсний тухай хууль;
- ✓ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль;
- ✓ Эрүүл ахуйн тухай хууль;
- ✓ Усны тухай хууль;
- ✓ ДЭМБ-аас боловсруулсан БЖИ тооцох (Z хүснэгт)
- ✓ Тогтвортой хөгжлийн зорилго 2030
- ✓ Өндөгний стандарт - MNS 0095: 77
- ✓ Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт
- ✓ Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

**Аудитын хамарсан
хүрээ:**

Тус аудитад хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг зохион байгуулан, бүх түвшинд хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих, мэдээллээр хангах чиг үүрэгтэй аймгийн Засаг дарга, түүний харьяа хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Статистикийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газруудын 2018-2021 оны

Аудитын арга зүй:

аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулан, аудитын арга зүйд тусгасан горим сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгөтэй холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитын 2 дугаар нэгжийн ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Л.Уранбилэг, Ч.Оюунтүлхүүр нар 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд аудитыг гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитын явцад холбогдох байгууллагуудын ирүүлсэн тоон мэдээлэл зөрүүтэй, нэгтгэсэн судалгаа, тоон мэдээлэл олдохгүй зэрэг бэрхшээл тулгарсан ба аудитын гүйцэтгэлийн үе шатанд аудитын багийн гишүүд Ковидын халдвар авч эмчлүүлснээс аудитыг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хүнсний аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Органик хүнсний тухай хууль, Баяжуулсан хүнсний тухай хууль, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, УИХ болон ЗГ-ын тогтоолоор баталсан үндэсний хөтөлбөрүүд, тогтоол, журмууд, хүнсний аюулгүй байдалтай холбоотой стандартууд болон бусад хууль, эрх зүйн актуудаар бүрдүүлсэн байна.

Дээрх үндэсний хөтөлбөр, хууль эрх зүйн хүрээнд аймгаас “Жимс жимсгэнэ”, “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийг баталж, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тариалан эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжих, дотоодын хэрэгцээний хүнсний ногооны 20 хувийг, жимс жимсгэнийн 0,3 хувийг хангах зорилт тавьжээ.

Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилтод хүнсний шим тэжээлтэй холбоотой 1 зорилт, хүнсний хангамж, хүртээмжтэй холбоотой 5 зорилт, эрүүл ахуйтай холбоотой 1 зорилтыг төлөвлөсөн байна.

“Дундговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 4 зорилтод хоолны шим тэжээлтэй холбоотой 1 арга хэмжээ, хүнсний хангамж, хүртээмжтэй холбоотой 11 арга хэмжээг тусгасан.

Хүнсний шим тэжээл болон хэрэглээний талаар аймгийн хэмжээнд статистик тоон мэдээлэл байхгүй, судалгаа шинжилгээ хийгдээгүй байна. Аймгийн жишсэн хүн амыг 38,456 гэж үзэн нэг хүний хоногийн болон жилийн хэрэгцээг 4 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр тооцоход дараах байдалтай байна. Үүнд:

Хүнсний бүтээгдэхүүн	Аймгийн жишсэн дундаж хүн ам	Хоногийн хэрэгцээ /тн/	Жилийн хэрэгцээ /тн/
Мах	38,456	4,614.7	55,375.9
Гурил	38,456	3,845.6	46,146.6
Төмс	38,456	4,614.7	55,375.9
Сүү	38,456	6,152.9	73,834.6

/эх сурвалж: Статистикийн хэлтэс/

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Дотоодын үйлдвэрлэл эзлэх хувь	18
Зураг 2	Органик хүнсний бүртгэл мэдээллийн систем Organic.gov.mn	21

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Хүнсний ногоо”, “Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт	11
Хүснэгт 2	Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой суулгалт өвчний тоон судалгаа /2016-2021 он/	15
Хүснэгт 3	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнэ, хэлбэлзлийн далайц, стандарт хазайлт	16
Хүснэгт 4	Гол нэрийн бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлийн эзлэх хувь	18
Хүснэгт 5	Сумдын хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтний судалгаа	20
Хүснэгт 6	Төмс, хүнсний ногооны ургац хураалтын тоон мэдээллийн зөрүү	20-21
Хүснэгт 7	Хүнсний зориулалтын бус хуванцар сав хэрэглэдэг өрхийн судалгаа	22
Хүснэгт 8	Хүнсний эрхийн бичиг авсан өрхийн тоо, төсөв, гүйцэтгэл	24

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	МХГ-ын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо	19
Дүрслэл 2	СХС-ийн зээл олголт /хувиар/	23
Дүрслэл 3	ЖДҮ дэмжих сангийн зээл олголт /хувиар/	23
Дүрслэл 4	Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан нийт өрхийн тоог амьжиргааны түвшний бүлгээр	24

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	“Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт”-ыг “аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төлөвлөгөөтэй уялдсан байдал	32-33
Хавсралт 2	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан 0-5 насны эрэгтэй, эмэгтэй хүүхдийн биеийн жингийн индексийн судалгаа	34-37
Хавсралт 3	Мэргэжлийн хяналтын газрын лабораторид шинжлүүлсэн ундны усны шинжилгээний дүн	38
Хавсралт 4	Аймгийн мэргэжлийн хяналтын газрын лабораторийн тоног төхөөрөмж хэрэгцээний судалгаа	39
Хавсралт 5	Хүнсний зориулалтын бус хуванцар сав хэрэглэдэг өрхийн судалгаа /2019 он/	40



БҮЛЭГ 1. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бодлого төлөвлөлт, эрх зүйн баримт бичгүүд болон байгууллага хоорондын уялдаа холбоо мүү, үйл ажиллагаа үр дүн багатай байна

1.1 Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой аймгийн бодлого, төлөвлөлт хангалтгүй, улсын хэмжээнд мөрдөгдөж буй зарим хууль, журам, стандартыг шинэчлэх шаардлагатай байна.

1.1.1 Аймагт хэрэгжиж буй бодлогын баримт бичигт тусгагдсан хүнсний аюулгүй байдалтай холбоотой зорилтуудын уялдаа бүрэн хангагдаагүй, хэрэгжилт хангалтгүй байна.



“Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт”-д хүнсний эрүүл ахуйтай холбоотой 2, шим тэжээлтэй холбоотой 3, хүрэлцээ, хангамжтай холбоотой 5, нийт 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бол, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд, шим тэжээлтэй холбоотой 3, хүрэлцээ, хангамжтай холбоотой 13, нийт 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. /Заалтуудыг Хавсралт I-ээс харна уу/

Дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалтуудыг харьцуулан үзэхэд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд аймгийн 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилтод тусгагдсан 5 арга хэмжээ, бүрэн тусгагдаагүй 2, огт тусгагдаагүй 9 арга хэмжээ байна. /Хавсралт I/

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй, “Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт”-ын хэрэгжилтийг тайлагнасан боловч бодитой үнэлж, үр дүнг тооцоогүй, зарим зорилт арга хэмжээний хувьд хийгдсэн ажил нь тодорхойгүй, зөвхөн тоон үзүүлэлтээр хэмжсэн ба аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс хяналт-шинжилгээ, үнэлгээ огт хийгдээгүй байна.

Аудитаар дээрх бодлогын баримт бичгийн 2020 онд хүрэх түвшнийг тайлагнасан хэрэгжилттэй харьцуулахад 10 зорилтын 16 арга хэмжээнээс 5 нь буюу 31% нь бүрэн хэрэгжсэн, 4 буюу 25% нь хэрэгжилт дутуу, 7 буюу 44% нь огт хэрэгжээгүй байна. //

Энэ нь аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслээгүй, бодитой бус, төсөл арга хэмжээ хэрэгжих санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлоогүй, жил бүр хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаагүй, хэрэгжилтийн үр дүнг тооцоогүйгээс шалтгаалжээ.

Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн бодлогын баримт бичигт хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгагдсан заалт хоорондын уялдаа холбоог хангуулах, тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоон, жил бүрийн хүрэх түвшин, хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт хийн, үр дүнг тооцон ажиллаж байх;

Мөн хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны "Дэд хөтөлбөр батлах тухай" 25 дугаар тогтоолоор “Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо” гэсэн дэд хөтөлбөрүүдийг батлан, хэрэгжүүлж байна.

Энэхүү дэд хөтөлбөрүүдийн зорилго, зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт нь аймгийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй байна. Энэ нь байгууллагуудын үйл ажиллагаа болон бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо муу, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах албан тушаалтан байхгүйтэй холбоотой байна. Эдгээр дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлангаас авч үзвэл:

“Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд 2022 онд хүн амын хүнсний ногооны хэрэгцээний 20%-ийг хангаж, нийт 70 га талбайд, 630 тонн ургац хураана гэж төлөвлөснөөс 2020 онд 43.1 га талбайд 369 тонн ургац хураан авч, хүн амын 17%-ийг хангасан гэж тайлагнажээ.

“Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөрийн хүрээнд 2022 онд нийт 80 га талбайд жимс жимсгэний тариалалт хийж, 10,000 ширхэг суулгацыг бэлтгэх нөхцөлийг бүрдүүлж, орон нутгийн хэрэгцээний 0.3-аас доошгүй хувийг хангахаар төлөвлөснөөс 2019-2020 онд 727 ширхэг суулгац тариалж, 2020 онд 61.4 га талбайд 4 тонн ургац хураан авсан ба энэ нь 2022 онд хүрэх түвшний 50 хувийг эзэлж байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 1 “Хүнсний ногоо”, “Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт

№	Үзүүлэлт	Хүнсний ногоо			Жимс жимсгэнэ		
		Хүрэх түвшин /2022/	2020 оны хэрэгжилт	Зөрүү	Хүрэх түвшин /2022/	2020 оны хэрэгжилт	Зөрүү
1	Талбай /га/	70	43.1	26.9	80	61.4	18.6
2	Ургац хураалт/тн/	630	369	261	8	4	4
3	Хүн амын хангамж /хувь/	20	17	3	0.3	0.14	0.16

Тус дэд хөтөлбөрүүдийн хүрэх түвшнийг зөвхөн 2022 оны байдлаар тогтоосон, завсрын хугацаанд хүрэх түвшнийг тодорхойлоогүй нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын үр дүнг үнэлэх, хэрэгжилт дутуу байх, удаашралтай хийгдэж байгаа ажлуудыг тодорхойлох боломжгүй нөхцөл байдал үүсэж байна.

Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланд тариалан эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн нэгдсэн судалгаа хийгдээгүй, гүйцэтгэлийг тодорхой тайлагнаагүй ба хөтөлбөрүүдийн санхүүжүүлэх эх үүсвэр дутмаг байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс дээрх хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцоогүй байна.

Энэ нь хөтөлбөрийн 8.1¹-т заасныг зөрчиж байгаа бөгөөд хөтөлбөрийг аймгийн бодлогын түвшинд төлөвлөж, хэрэгжилтийг тооцож, үнэлэх, шинэчлэн сайжруулах зэрэг ажлууд хийгдэхгүй байх үр дагаврыг бий болгож байна.

Цаашид тус хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хийгдэх ажлыг тодорхой болгон, аймгийн бодлогын баримт бичгүүдэд санхүүжилтийн эх үүсвэрийн хамт тусгах шаардлагатай байна.

1.1.2 Хүнсний сүлжээний бүх үе шатны чанар, эрүүл ахуй, аюулгүй байдал, хадгалалт, тээвэрлэлт, хүнсний хангамжтай холбоотой үндэсний стандарт, хууль, дүрэм журам батлагдан мөрдөгдөж байгаа хэдий ч зарим стандарт, хууль журам нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй, шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний нэг болох өндөгний стандарт 1977 онд MNS 0095: 77 техникийн шаардлагаар батлагдан гарсан боловч одоог хүртэл стандартыг шинэчлээгүй ба өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.

Тус стандарт нь зөвхөн сувиллын болон гуанзны зориулалтаар ашиглах өндөгний хүрээнд зохицуулагдсан бөгөөд ахуйн хэрэглээний өндгөнд тавигдах шаардлага, хадгалах горим зэргийн талаар тусгагдаагүй, стандарт батлагдсанаас хойш өндөгний үйлдвэрлэл, төрөл зүйл нэмэгдсэн зэрэг нь тус стандарт нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаагүй, шинэчлэх шаардлагатайг харуулж байна.

Иймд өндөгний үндэсний стандартыг олон улсын стандарт, үндэсний үйлдвэрлэлийн онцлогт нийцүүлэн боловсруулж, дагаж мөрдүүлэх талаар холбогдох байгууллагад хүргүүлэх саналыг УАГ-т уламжиллаа.

Хууль, дүрэм журмын хүрээнд:

Хүнсний аюулгүй байдлыг хангах гол үзүүлэлтүүдийн нэг болох стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэлтийн талаар хуульд тусгагдсан боловч түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам батлагдан гараагүй, нөөцийг бүрдүүлэх ажил хийгдэхгүй байна.

Энэ нь Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2², 6.3³-т заасныг зөрчиж байна. Стратегийн хүнсний нөөц бүрдүүлэхгүй байгаа нь гэнэтийн, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүнсний хомсдолд орох, иргэд, олон нийт хоол тэжээлийн дутагдалд орох эрсдэлийг бий болгож байна.

Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг боловсруулж, батлуулах талаар холбогдох байгууллагад хүргүүлэх саналыг УАГ-т, аймгийн хэмжээнд хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах талаар зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

¹ Хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс гүйцэтгэнэ.

² Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална

³ Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 6.2-т заасан журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ

Хүнсний аюулгүй байдлыг хэмжих гол үзүүлэлтүүдийн нэг болох өлсгөлөнгийн талаар Тогтвортой хөгжлийн зорилго 2-д 2030 он гэхэд өлсгөлөнг зогсооно гэж тусгагдсан боловч өлсгөлөнгийн үзүүлэлтийг тооцдоггүй, заавар аргачлал гараагүй байна.

Олон улсын туршлага:

Дэлхийн өлсгөлөнгийн индексийг тооцох аргачлал: Өлсгөлөнгийн индексийг тооцоход доорх 4 үзүүлэлтийг авч үздэг.



эзлэх хувь (СМ Хүүхдийн эндэгдэл)

- Хоол тэжээлийн дутагдалд орсон хүн амын эзлэх хувь (PUN)
- Таваас доош насны тураалтай хүүхдийн эзлэх хувь (CWA Өндрийн хувьд бага жинтэй)
- Таваас доош насны өсөлтийн хоцрогдолтой хүүхдийн эзлэх хувь (CST Насны хувьд бага өндөртэй)
- Таван нас хүрэхээс өмнө эндсэн хүүхдийн

$$\frac{1}{3} \times \text{Стандарт PUN} + \frac{1}{6} \times \text{Стандарт CWA} + \frac{1}{6} \times \text{Стандарт CST} + \frac{1}{3} \times \text{Стандарт СМ} = \text{ДӨИ}$$

оноо /Эх сурвалж: www.globalhungerindex.org /

Тогтвортой хөгжлийн зорилтын 2.2⁴, 2.2.1⁵, 2.2.2⁶-д тав хүртэлх насны хүүхдийн өсөлтийн хоцролттой, туранхай, илүүдэл жинтэй хүүхэд нь ДЭМБ-аас боловсруулсан биеийн жингийн индексийн үзүүлэлтийн стандарт дунджаас зөрүүтэй бол тэдгээр хүүхдийн тархалтын хэмжээг тооцож, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн зорилтуудад хүрэх замаар хоол тэжээлийн дутагдлын бүх хэлбэрийг арилгана гэж тусгагдсан боловч эдгээр үзүүлэлтийг тооцох аргачлал, журмыг батлаагүй байна.

ДЭМБ-аас боловсруулсан тав хүртэлх насны эрэгтэй, эмэгтэй хүүхдийн биеийн жингийн индексийн Z онооны хүснэгтийг хавсралтаар орууллаа. /Хавсралт №2/

Эрүүл мэндийн сайд, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/514 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар “Хүүхдийн биеийн жин, өндрийг бүртгэх тандах журам”-ын дагуу 6-19 насны хүүхдийн биеийн

⁴ 2025 он гэхэд 5 хүртэлх насны өсөлтийн хоцролттой, туранхай хүүхдийн талаар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн зорилтуудад хүрэх замаар хоол тэжээлийн дутагдлын бүх хэлбэрийг арилгаж, өсвөр насны охид, жирэмсэн болон хүүхдээ хөхөөрөө хооллож буй эмэгтэйчүүд, өндөр настнуудын хоол тэжээлийн хэрэгцээг 2030 он гэхэд хангах

⁵ Өсөлтийн хоцролттой 5 хүртэлх насны хүүхдийн тархалт (Биеийн өндөр, насны харьцаа нь ДЭМБ-аас боловсруулсан хүүхдийн өсөлтийн стандарт харьцааны голчоос "- 2 стандарт хазайлтаас" доогуур)

⁶ Хоол тэжээлийн дутагдалтай 5 хүртэлх насны хүүхдийн тархалт, төрлөөр (туранхай ба илүүдэл жинтэй), (Биеийн жин, өндрийн харьцаа нь ДЭМБ-аас боловсруулсан хүүхдийн өсөлтийн стандарт харьцааны голчоос "+2 стандарт хазайлтаас" их эсвэл "- 2 стандарт хазайлтаас" доогуур)

урт/өндөр, биеийн жингийн индексийг тооцох талаар аргачлал гарсан боловч 0-5 хүртэлх насны хүүхдийн БЖИ-ийг тодорхойлох журам гараагүй байна.

Иймд тогтвортой хөгжлийн зорилго 2-ын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, заавар журмыг боловсруулж, батлуулах, хэрэгжилт үр дүнг тооцон, жил бүрийн хүрэх түвшнийг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг нэгдсэн зохион байгуулалтайгаар хийж байх талаар холбогдох байгууллагад хүргүүлэх саналыг УАГ-т уламжиллаа.

1.2 Хүнсний аюулгүй байдлыг хангах, хэрэгжүүлэх, хянах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо муу, бүтэц чиг үүрэг тодорхой бус байна.

1.2.1 Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах нэгдсэн зохицуулалт байхгүй байна.

Хүнсний тухай хуульд хүнсний аюулгүй байдлыг хангахад хүнсний хангамж тогтвортой, хүртээмжтэй байх, хүнс нь эрүүл мэндэд шаардлагатай шим тэжээлэг найрлагатай байх, хүний эрүүл мэнд амь насанд гэм хор учруулаагүй байх, хүнсний талаарх мэдээлэл үнэн зөв, ил тод, бодитой байх гэсэн зарчмуудыг баримтлах талаар тусгагдсан.

Тус зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймагт хүнсний хангамж, хүртээмжийг ХХААГ, эрүүл, аюулгүй байдалтай холбоотой асуудлыг МХГ, шим тэжээлтэй холбоотой асуудлыг Эрүүл мэндийн газраас тус тус хариуцан үйл ажиллагаа явуулж байгаа боловч хийгдэх ажил, чиг үүрэг, зохион байгуулалтын талаар аймгийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй, байгууллага хоорондын уялдаа холбоо муу байна.

Тухайлбал хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн статистик тоон мэдээллийг байгууллагууд зөрүүтэй гаргадаг, МХГ-аас гаргасан лабораторийн шинжилгээний дүгнэлт, зөрчлийн дүнд үндэслэн олон нийтэд сургалт, сурталчилгаа хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлууд хийгдэхгүй байна. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд статистик тоон мэдээлэл цуглуулах, нэгтгэн дүн шинжилгээ хийх ажлуудыг хийгээгүй байна. /Дэлгэрэнгүйг АЗ бүлгээс харна уу/

Энэ нь хүнсний аюулгүй байдлыг хангах асуудлыг нэгдсэн удирдлага, арга зүй, чиглэлээр хангах байгууллага, зөвлөл, албан тушаалтан байхгүй байгаатай холбоотой байна. Үүнээс шалтгаалан аймгийн хэмжээнд хүнсний аюулгүй байдалтай холбоотой бодлого, эрх зүйн орчин хангалтгүй байх, цаашидад хүнсний аюулгүй байдал алдагдах үр дагаврыг бий болгож байна.

Хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, хууль, эрх зүй, бодлогын хэрэгжилтийг хангуулах ажлын хэсэг ажиллуулах шаардлагатай байна.

1.2.2 Хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан хордлого, халдварын тохиолдол, онцгой нөхцөл байдал үүссэн үед хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах зохицуулалт хангалтгүй байна.

Аймагт олон нийтийг хамарсан хоол, хүнсний хордлого, халдварын тохиолдол бүртгэгдээгүй боловч гэнэтийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний талаар аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодорхой нарийвчилсан заалт тусгагдаагүй байна. Үүнээс шалтгаалан аймагт хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан өвчлөл, гамшгаас урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулж чадахгүй байх үр дагавартай байна.

Иймд хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой аймагт тохиолдож болзошгүй олон нийтийг хамарсан хоол, хүнсний хордлого, халдварт өвчин, хүнсний хомсдол үүсэх болон бусад эрсдэлтэй асуудлуудыг тодорхойлон, түүнийг арилгах, урьдчилан сэргийлэх, тодорхой арга хэмжээнүүдийн талаар аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд хүнсний бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой суулгалт өвчин 2018 онд 524, 2019 онд 574, 2020 онд 576 бүртгэгдсэн буюу жил бүр өссөн үзүүлэлттэй гарч байна. /Хүснэгт №2 / Тус өвчин нь ямар шалтгааны улмаас бий болсныг тодорхойлоогүй, өвчлөлийг хэрхэн бууруулах, урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд мэдээлэл сурталчилгаа хийх ажил хангалтгүй байна.

*Хүснэгт 2 Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээтэй
холбоотой суулгалт өвчин /Эх сурвалж: ЭМГ/*

Он	Суулгалт	Цусан суулга	Хоолны бактери
2016	246	1	
2017	234		
2018	524	4	1
2019	574	3	
2020	576	3	
2021 Эхний хагас жил	150	1	

Иймд хоол, хүнсний бүтээгдэхүүнээс шалтгаалсан өвчлөлийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, түүнийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа, мэдээллийг олон нийтэд хүргэж, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

1.3. Аймгийн хүн ам эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой, хүртээмжтэй хангагдах баталгаа, нөхцөл бүрдээгүй байна.

1.3.1 Аймагт хүнсний бүтээгдэхүүний улирлын стратеги нөөцийг бүрдүүлдэггүй, гэнэтийн болзошгүй нөхцөл байдал үүссэн үед хүнсний хомсдолд орох эрсдэлтэй байна.

Хүнсний стратеги нөөц бүрдүүлэх, зарцуулах талаар тодорхой журам гараагүй, нөөц бүрдүүлэх төсөв хөрөнгө байдаггүйгээс аймгийн хэмжээнд стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхгүй байна. Мөн аймгийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд хүнсний нөөц бүрдүүлэлт болон гэнэтийн, онцгой нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээний талаар нарийвчилсан тодорхой заалтууд байхгүй байна.

Харин сумдын жижиг дунд үйлдвэрлэл, хүнс хариуцсан мэргэжилтэн нь тухайн сумын аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, дэлгүүр, цех, хувиараа үйлдвэрлэл

эрхлэгчээс 7 хоногт 1 удаа хүнсний бүтээгдэхүүний нөөцийн мэдээллийг авч ХХААГ-т нэгтгэн мэдээлдэг байна. Тус мэдээллээс авч үзэхэд 2021 онд дийлэнх хугацаанд хүнсний бүтээгдэхүүний хомсдол үүсээгүй боловч 2021 оны 6 дугаар сарын сүүлийн хоёр 7 хоногт махны нөөцгүй, бусад хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэл харьцангуй бага байсан талаар мэдээлсэн байна. /Хавсралт №4/ Энэ нь хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна.

Аудитаар өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд 2017-2021 оны үнийн өсөлтийн дундаж⁷ хурд нь 100.2 хувиас 101.9 хувь буюу урт хугацааны дунджаар үнэ өсөлтгүй гарч байгаа боловч дийлэнх бүтээгдэхүүний үнэ тогтворгүй, савлагаа ихтэй байна. /Хавсралт №5/

Мөн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн стандарт хазайлт, харьцангуй дисперсийг тооцоолон үзэхэд төмс, өндөг, хонь, ямааны мах зэрэг бүтээгдэхүүний стандарт хазайлт өндөр, харьцангуй дисперс 23.2-27.6 хувьтай буюу үнийн савлагаа хамгийн өндөр гарч байна.

Тухайлбал хонины махны үнэ хамгийн багадаа 4,000 төгрөг байсан бол хамгийн өндөр нь 13,000 төгрөгт хүрч үнийн хэлбэлзлийн далайц нь 9,000 төгрөг буюу үнэ 3.2 дахин зөрүүтэй, төмсний үнэ хамгийн бага нь 580 төгрөг, хамгийн өндөр нь 1,997 төгрөгт хүрч үнийн хэлбэлзлийн далайц 1,417 төгрөг буюу 3.4 дахин зөрүүтэй, өндөгний үнэ хамгийн багадаа 253 төгрөг байсан бол, хамгийн өндөр нь 577 төгрөгт хүрч, үнийн хэлбэлзлийн далайц нь 324 төгрөг буюу 2.3 дахин зөрүүтэй байна. /Хүснэгт №3/

Хүснэгт 3 Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнэ, хэлбэлзлийн далайц, стандарт хазайлт

Бүтээгдэхүүний нэр	Хамгийн өндөр үнэ	Хамгийн бага үнэ	Өсөлтийн дундаж хурд 5 жилээр	Дундаж үнэ	Стандарт хазайлт ⁸	Харьцангуй дисперс ⁹ %
Гурил	1,650.0	1,200.0	100.4	1,353.8	154.1	11.4
Мах /хонины/	13,000.0	4,000.0	100.7	7,022.4	1,883.8	26.8
Мах /Ямааны/	11,000.0	3,500.0	100.8	6,210.3	1,656.5	26.7
Элсэн чихэр	2,580.0	1,800.0	100.2	2,158.3	241.5	11.2
Цагаан будаа	2,630.0	2,200.0	100.3	2,384.4	145.5	6.1
Талх	1,750.0	950.0	101.4	1,174.7	168.8	14.4
Өндөг	577.0	253.0	100.8	385.1	89.4	23.2
Төмс	1,997.0	580.0	101.9	1,103.8	304.5	27.6

Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнийн савлагаа нь амьжиргааны түвшинээс доогуур орлоготой, эмзэг бүлгийн айл өрхөд хүндээр нөлөөлж, хоол хүнснээс

⁷ Сүүлийн 5 жилийн өсөлтийн хувийн геометр дунджаар тооцоолсон

⁸ Эх олонлогийн утгуудын дундаж утгаас хэлбэлзэх хэлбэлзлийн абсолют утгыг стандарт хазайлт гэнэ. Өөрөөр хэлбэл хүнсний бүтээгдэхүүний үнэ сүүлийн 5 жилийн үнийн дундажаас хэлбэлзэх хэмжээг илэрхийлж байна.

⁹ Харьцангуй дисперс гэдэг нь стандарт хазайлт нь дундаж үзүүлэлтийн хэдэн хувийг эзэлж байгааг харуулна. Өөрөөр хэлбэл дундаж үнээс хэлбэлзэж байгаа үнийн хэлбэлзлийн эзлэх хувийг илэрхийлнэ.

хоногт авах шаардлагатай илчлэг, шим тэжээлийг авч чадахгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Махны үнэ савлагаа ихтэй байсан нь байгалийн гамшигт үзэгдэл, хур тунадасны хэмжээ, отор нүүдэл, ган, зуд зэрэг байгаль цаг уурын нөхцөл байдалтай холбоотой байсан бол бусад хүнсний бүтээгдэхүүнүүд нь Ковид-19 цар тахлын хөл хорио, тээврийн зардлын өсөлт, стратегийн хүнсний нөөц бүрдүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Дундговь аймагт 2021 оны 4 сард байгалийн онц аюултай гамшигт үзэгдэл тохиолдсоны улмаас хүчтэй шороон шуурга тавьж, нийт 137.2 мянган толгой мал хорогдсон байна.

1.3.2 Хүнсний шим тэжээл, чанар, аюулгүй байдлыг шинжлэх зарим лабораторийн тоног төхөөрөмж дутагдалтай байна.

Аймгийн МХГ-ын сорилтын лабораторид шинжилгээ хийдэг 46 тоног төхөөрөмж байгаагаас термостат, анерастат, микроскоп, автоклав зэрэг 5 тоног төхөөрөмжийг засварлах хэрэгтэй ба 7 тоног төхөөрөмжийг шинээр авах шаардлагатай байна. */Жагсаалтыг хавсралт 6-аас харна уу/*

Монгол Улсын хууль, үндэсний стандартад хүнсний бүтээгдэхүүний зарим үзүүлэлтүүдийг тооцож байхаар заасан боловч тоног төхөөрөмжийн дутагдалтай байдлаас шалтгаалан дараах үзүүлэлтүүдэд шинжилгээ хийх боломжгүй байна.

Үүнд ундны усны аюулгүйн үзүүлэлт, макро, микро элемент, хүнд металл илрүүлэх шинжилгээ ба шим тэжээлийн үзүүлэлтээс уургийн хэмжээ, транс тос илрүүлэх, хүнсний ногоонд пестицидийн үлдэгдэл тодорхойлох, гений өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг шинжлэх лабораторийн тоног төхөөрөмжгүй байна.

Аудитын явцад талх, нарийн боов, орон нутгийн үйлдвэр эрхлэгч, нийтийн хоолны газар, сургуулийн хэрэгцээнд ашигладаг ундны усны шүүлтүүрийн болон крантны усыг МХГ-ын лабораторид, зориулалтын байранд болон ил задгайгаар худалдаалагдаж байгаа маханд аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторид тус тус шинжилгээ хийлгэлээ.

Шинжилгээний үзүүлэлтүүд стандартын шаардлагад нийцсэн гэж гарч байгаа хэдий ч усны шинжилгээгээр үйлдвэрийн аргаар шүүсэн ус нь энгийн шүүлтүүртэй болон крантны усыг бодвол харьцангуй бага хатуулагтай байгаа боловч эрдэс бодисын үзүүлэлт болох кальци, магни, сульфат нь бага үзүүлэлттэй гарсан байна. */Хавсралт 3 /*

Ундны усны шинжилгээний дүгнэлтэд үндэслэн усны чанар, эрдэс бодисын үзүүлэлтэд дүн шинжилгээ хийн, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар болон ундны усны шүүлтүүрийн үр дүнг үнэлээгүй, ач холбогдлын талаар олон нийтэд сургалт, сурталчилгаа явуулах ажил хийгдээгүй байна. Энэ нь төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа муу байгаатай холбоотой байна.

Иймд ундны усны шинжилгээний дүгнэлтэд үндэслэн шүүлтүүрийн болон төвлөрсөн шугамын усны хатуулаг, эрдэс бодисын хэмжээний ялгаа, хүний эрүүл мэнд, хоногт авах эрдэс бодисын хэмжээний тооцоололд хэрхэн нөлөөлөх талаар иргэд олон нийтэд мэдээлэл сурталчилгаа хийх шаардлагатай байна.

1.3.3 Хүнсний бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлийн хэмжээ хангалтгүй, хүнсний хангамж, нийлүүлэлт нь Улаанбаатарын үйлдвэрлэл болон импортын хэмжээнээс ихээхэн хамааралтай байна.

Хүснэгт 4 Гол нэрийн бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлийн эзлэх хувь

Жишсэн хүн амын жилийн хэрэгцээг тооцоход ашигладаг 16 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээс 6 нэр төрлийн бүтээгдэхүүнийг орон нутагт үйлдвэрлэдэг бол бусад хүнсний бүтээгдэхүүнийг импортоор болон Улаанбаатар хотоос авч байна. /Эх сурвалж: ХХААГ, МЭГ/

Орон нутгийн үйлдвэрлэлээс бусад хүнсний бүтээгдэхүүний статистик тоон мэдээлэл аймагт гардаггүй учир дотоодын болон импортын бүтээгдэхүүний харьцааг тооцох боломжгүй байна.

Гол нэрийн бүтээгдэхүүн	2020 он		
	ЖХА	Үйлдвэрлэлийн хэмжээ	Орон нутгийн үйлдвэрлэлийн эзлэх хувь
Төмс	299	186.9	62.5
Сүү	49,706.9	39,215.3	78.8
Хүнсний ногоо	359.9	131	36.4
Мах/тн/	16,612.7	39,409.8	237.2
Талх /тн/	618.8	122.9	19.9
Нарийн боов	747.5	133.3	17.8

Зураглал 1



Аудитаар аймгийн жишсэн хүн амын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний жилийн хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлтэй харьцуулан, тооцоолол хийхэд нийт хэрэгцээний **0.13¹⁰** хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Хүнсний бүтээгдэхүүн тус бүрээр авч үзвэл нийт махны хэрэгцээг орон нутгаас бүрэн хангаж байгаа бол сүү, сүүн бүтээгдэхүүний 78.8 хувийг, хүнсний ногооны 36.4 хувийг, талх, нарийн боовны 17.8-19.9 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.

Орон нутгийн үйлдвэрлэлийн хэмжээ хангалтгүй байгаа нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжих аймгийн бодлого, төлөвлөлт болон түүний хэрэгжилт хангалтгүй байгаагаас гадна аймгийн газарзүйн байршил, байгаль цаг уурын нөхцөл байдлаас хамааралтай байна.

Иймд аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд орон нутгийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаар бодитой ажлуудыг санхүүгийн эх үүсвэрийн хамт төлөвлөн, хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллах шаардлагатай байна.

¹⁰ Орон нутагт 2020 онд үйлдвэрлэсэн өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний нийт үнийн дүнг 2020 оны жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээний нийт үнийн дүнд харьцуулан тооцсон. Тус үзүүлэлтүүдийг тооцохдоо өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнүүдийн дундаж үнийг ашигласан болно.

1.3.4 МХГ-аас хүнсний сүлжээний үе шатуудад хяналт шалгалт хийж байгаа боловч байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил давтан гарсаар байна.

Аймгийн МХГ-аас 2016-2020 онд хүнсний чиглэлээр нийт төлөвлөгөөт 394 хяналт шалгалтад 1,453 объектыг хамруулж 6,736 зөрчил илрүүлсэн бол төлөвлөгөөт бус 6 хяналтад 9 объектыг хамруулж 24 зөрчил илрүүлсэн байна. Харин гүйцэтгэлийн хяналтад 321 объект хамрагдаж зөрчил илрээгүй байна.

МХГ-ын 2016-2020 онд гүйцэтгэсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн тоог, зөрчлийн ангиллаар авч үзэхэд ариун цэвэр, эрүүл ахуйтай холбоотой зөрчил нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Дүрслэл 1 МХГ-ын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо



/Эх сурвалж: МХГ/

Худалдаа үйлчилгээ болон хоол үйлдвэрлэлийн газруудад дараах зөрчлүүд давтан гарсаар байна. Үүнд:

- Өдөр тутмын цэвэрлэгээ хийх хуваарьгүй;
- Ариутгал халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгээгүй;
- Үйлдвэрлэлийн технологийн явцад шаардлагатай үзүүлэлтэд хяналт тавиагүй;
- Ундны ус хадгалах савыг 7 хоногт 1-2 удаа угааж халдваргүйжүүлдэггүй;
- Үйлдвэрийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дүрмийг батлуулаагүй;
- Зөвлөх, эрүүл ахуйчгүй гэх мэт.

Эдгээр зөрчлийн дийлэнх хувь нь сумдад гарч байгаа бөгөөд энэ нь суманд хяналт шалгалт хийх эрхтэй албан хаагч байхгүй, хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэнд хариуцуулсантай холбоотой байна.

Сумдын хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, усан хангамж хариуцсан мэргэжилтнүүд нь тогтвор суурьшилтай ажилладаггүй, одоогийн байдлаар нийт 10 сул орон тоо байна. Одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн ажлын туршлагыг авч үзвэл 5 хүртэл жил ажилласан 21 албан хаагч буюу нийт ажилчдын 70 хувийг, 5-аас дээш жил ажилласан 9 албан хаагч буюу нийт ажилчдын 30 хувийг эзэлж байна. Энэ нь тус ажлын байранд иргэд тогтвор суурьшилтай ажиллахгүй байгааг харуулж байгаа бөгөөд суманд хүнс, хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой ажлууд хийгдэхгүй орхигдох эрсдэлийг бий болгож байна.

Хүснэгт 5 Сумдын хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтний судалгаа

№	Мэргэжилтэн	Батлагдсан албан тушаал				Хэдийгээр сумдад аймгийн МХГ-ын улсын байцаагч нар ажилладаг ч өдөр тутмын хяналт шалгалт хийх боломжгүйгээс
		0-2 жил	3-5 жил	5-с дээш	Сул орон тоо	
1	Бэлчээр тэжээл, усан хангамж хариуцсан	5	5	5	8	Хэдийгээр сумдад аймгийн МХГ-ын улсын байцаагч нар ажилладаг ч өдөр тутмын хяналт шалгалт хийх боломжгүйгээс
3	ЖДҮ, хоршоо, хүнс худалдаа хариуцсан	6	5	4	2	

сумдад хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалт, эрүүл ахуйтай холбоотой эрсдэлүүд бий болох, хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй байна.

Иймд сумдын хүнс, хөдөө аж ахуй, усан хангамж хариуцсан албан тушаалтныг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хүнсний сүлжээний бүх үе шатад хяналт тавих эрх, үүргийг холбогдох хуулиар олгож, хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай байна.

1.3.5 Аймгийн хэмжээнд нийлүүлэгдсэн импортын болон дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүний тоон мэдээллийг бүртгэж, хяналт тавиагүй, органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих талаар бодлого, үйл ажиллагаа хангалтгүй байна.

Импортээр болон Улаанбаатараас нийлүүлэгддэг хүнсний бүтээгдэхүүн, сумдад борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, нийт худалдан авалт, хэрэглээ, хэрэглэсэн илчлэг, шим тэжээлийн талаарх тоон мэдээллийг бүртгэж цуглуулах, нэгтгэн дүгнэх ажлууд хийгдэхгүй байна.

Аймагт үйлдвэрлэсэн, тариалсан хүнсний бүтээгдэхүүний тоон мэдээллийг бүртгэдэг боловч байгууллага хоорондын мэдээлэл зөрүүтэй байна.

Хүснэгт 6 Төмс, хүнсний ногооны ургац хураалтын тоон мэдээллийн зөрүү

Он	ХХААГ		Статистик		Зөрүү	
	Төмс /тн/	Хүнсний ногоо /тн /	Төмс /тн/	Хүнсний ногоо /тн /	Төмс /тн/	Хүнсний ногоо /тн /
2019	208	125	186.9	90.6	21.1	34.4
2020	239.4	131	246.1	118.3	-6.7	12.7

/Эх сурвалж: ХХААГ, Статистикийн хэлтэс/

Зураг 2 Органик хүнсний мэдээллийн систем



ОРГАНИК ХҮНСНИЙ
МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГАХ

* Бүтээгдэхүүний код:

Шалгах

Органик хүнс нь мал аж ахуй, газар тариалангийн органик үйлдвэрлэлийн болон цэвэр байгалийн гаралтай, Монгол Улсын болон олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүнийг хэлдэг бөгөөд аймгаас органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин ажилласнаар орон нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэлийг эрхлэх боломж байна.

Гэвч орон нутгийн хэмжээнд органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих талаар аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй, аймагт органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж, хувь хүн байхгүй

байна.

Энэ нь органик хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлах ажил хангалтгүй, бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, баталгаажуулалт болон Organic.gov.mn системд хэрхэн бүртгэл хийгддэг талаар мэдээллийг үйлдвэрлэл эрхлэгчдэд хүргэх ажил хийгдээгүйгээс шалтгаалж байна.

Цаашид органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих талаар аймгийн бодлогын баримт бичигт тусган, үйлдвэрлэл эрхлэгч нарт органик бүтээгдэхүүнд тавигддаг шаардлага, бүртгэлжүүлэлт болон баталгаажуулалтын ажил хэрхэн хийгддэг талаар таниулах, мөн олон нийтэд органик бүтээгдэхүүний ашиг тусын талаар мэдлэг олгох сургалт сурталчилгааны ажлыг хийх шаардлагатай байна.

1.3.6 МХГ-ын шалгалтын дүнгээс хүнсний сав, баглаа боодол, хаяг шошготой холбоотой зөрчил буурсан байгаа ч айл өрхийн дийлэнх хувь нь хүнсний зориулалтын бус сав ашиглаж байна.

Дундговь аймгийн МХГ-аас 2016-2020 оны төлөвлөгөөт шалгалтаар 248 объектод хяналт хийснээс сав баглаа боодол, хаяг шошготой холбоотой нийт 407 зөрчил илрүүлсэн байна. Үүнээс 2016 онд хамгийн өндөр буюу 158, 2017 онд 127, 2018 онд 27, 2019 онд 63, 2020 онд 32 зөрчил илэрч өмнөх оноос 49,3 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа ч импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл Монгол, Орос, Англи хэлний аль нэг дээр бичигдээгүй зөрчил арилахгүй, давтагдан гарсаар байгаа нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсэгт бодит байдал дээр хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Энэ нь Чөлөөт зах зээл өргөжих тусам импортоор орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж Европ, Азийн улс орноос ялангуяа БНХАУ-аас импортын хүнсний бүтээгдэхүүн ихээр орж ирж байгаа боловч түүнд хяналт тавих нэгдсэн зохион байгуулалт, тогтолцоо бүрдээгүйтэй холбоотой байна.

Энэ нь иргэд өдөр тутам хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний заавар, орц найрлагатай танилцаж, хоногт авах илчлэг, шим тэжээлийн хэмжээг тооцоолох боломжгүй болох эрсдэлийг бий болгож байна.

Иймд импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүний хаяг шошгыг хуулиар зөвшөөрсөн хэлээр байршуулах шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллагууд улсын хэмжээнд нэгдсэн байдлаар тавих шаардлагатай байна.

ЭМГ-аас 2019 онд хийсэн хүнсний сав баглаа боодлын чиглэлээр аймгийн төв болон сумдын гэр хороололд амьдардаг 14,194 өрхийг хамруулсан судалгаагаар нийт өрхийн 50.4 хувь нь зориулалтын бус сав ашигладаг, 39.8 хувь нь зориулалтын сав ашигладаг гэсэн бол үлдсэн 9.8 хувь нь цэвэр усны төвлөрсөн сүлжээнд холбогдсон гэсэн байна. /Хүснэгт №7/

Хүснэгт 7 Хүнсний зориулалтын бус хуванцар сав хэрэглэдэг өрхийн судалгаа /Эх сурвалж: ХОХБТХ/

Аймгийн хэмжээнд	Нийт өрхийн тоо /2019 он/	Зориулалтын бус сав	Зориулалтын сав	Төвлөрсөн сүлжээнд холбогдсон
Нийт	14,194	7,162	5,663	1,369

Судалгаанд хамрагдсан иргэдээс хуванцар сав олдоц ихтэй, үнэ хямд байдгаас ундны ус, сүү, айраг зэрэг хүнсний шингэн

бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэхэд зориулалтын бус сав өргөнөөр хэрэглэж байгаа талаар саналаа илэрхийлсэн байна. /Хавсралт 7 /

Энэ нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй боловч судалгааны үр дүнд үндэслэн цаашид хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Эрүүл мэндийн газраас 2017-2020 онд хүн амыг эрүүл, зөв хоол хүнс хэрэглэх дадалд сургах, гэр зөвлөмжийн талаар, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр эрүүл мэндийн төвүүд, сургуулийн тогооч, эмч, нийтийн хоолны газрууд болон олон нийтэд 72 сэдвээр 10,767 иргэнийг хамруулсан сургалт зохион байгуулж, тараах материал өгч ажилласан ч сургалтын хэрэгжилт, үр дүнг тооцоогүй байна.

Сургалтын хэрэгцээ шаардлагыг мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, лабораторийн шинжилгээний дүн болон хүнсний бүтээгдэхүүнээс шалтгаалсан өвчлөлийн тоон мэдээлэлд үндэслэн боловсруулдаггүй, сургалтын үр дүнг тооцож, дүн шинжилгээ хийдэггүйтэй холбоотой байна.

Мөн эрүүл мэндийн газрын орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээ хариуцсан ажилтан нь хоол тэжээл, хүнсний аюулгүй байдалтай холбоотой ажлыг давхар хариуцан гүйцэтгэдэг нь тухайн ажлын үр дүнд нөлөөлөхөөр байна.

Иймд мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн байнга давтагдан гарч буй зөрчил, лабораторийн шинжилгээний дүн, хүнсний бүтээгдэхүүнээс шалтгаалж болох өвчлөлийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, түүнд үндэслэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, үр дүнг тогтмол тооцон ажиллаж байх шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой төсвөөс зарцуулсан хөрөнгө хангалтгүй, төсвийн хуваарилалт үр дүн муутай байна.

Орон нутгийн төсөвт хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой төсөв батлагдаагүй, улсын төсвөөс хүнсний нөөц бүрдүүлэлттэй холбоотой дэмжлэг, урамшуулал олгодог боловч Дундговь аймагт төсөв хуваарилагдаагүй байна.

2.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сангаас хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр олгосон зээл нь орон нутгийн үйлдвэрлэлд бодитой хувь нэмэр оруулаагүй байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгөөс хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 2019-2021 онд нийт 12 үйлдвэрлэгчдэд 529.7 сая төгрөгийн зээлийг 5 жилийн хугацаатайгаар олгосон байна. /Дүрслэл 2- ЖДҮ дэмжих сангийн зээл олголт/



Нийт зээлээс 308.8 сая төгрөг буюу 58.3 хувь нь мах ангилах дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 123.4 сая төгрөг буюу 23.3 хувь нь төмс, хүнсний ногоо, 97.4 сая төгрөг буюу 18 буюу 18.4 хувь нь бусад чиглэлээр олгогдсон байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 2019-2021 онд нийт 54 үйлдвэрлэгчдэд 887.7 сая төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатайгаар олгосон байна. /Дүрслэл 3- СХС-ийн зээл олголт/

Нийт зээлээс 232.6 сая төгрөг буюу 26.2 хувь нь талх нарийн боовны үйлдвэрлэл, 246.0 сая төгрөг буюу 27.7% нь мах ангилах дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 172.9 сая төгрөг буюу 19.5% нь төмс, хүнсний ногоо, 235.9 сая төгрөг буюу 26.6% сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэлийн чиглэлээр олгогдсон байна.




Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 2019-2021 онд нийт 1,417.4 сая төгрөг зээл олгосноос 554.8 сая төгрөг буюу 39.3 хувь нь мах ангилах дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр зээл авсан боловч эдгээр төсөл нь махны үйлдвэрлэл эрхлэх бус малчдаас мал авч дамжуулан борлуулах үйл ажиллагааг эрхэлж байна. Мөн аудитын явцад мах ангилах дайвар бүтээгдэхүүний чиглэлээр зээл авсан 5 зээлдэгчийн үйл ажиллагаатай танилцахад 3 нь зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй байсан зэрэг нь сангаас олгож байгаа зээл нь үр дүн муутай гэж дүгнэж болохоор байна. Иймд Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сангаас аймаг, сумдын хөгжлийн бодлогын баримт бичиг, тэргүүлэх чиглэлд нийцсэн, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих, хэрэгжих боломжтой төсөлд зээл олгож байх шаардлагатай байна.

2.2 Төрөөс өрхийн амьжиргааны түвшин доогуур айл өрхөд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж байгаа ч өрхийн орлогын түвшнийг харгалзахгүй, ижил хэмжээгээр олгож байгаа нь зарим өрхийн хувьд өдөрт авбал зохих илчлэг, шим тэжээлийг авч чадахааргүй байна.

Дундговь аймгийн ХХҮГ-аас 2017 онд аймгийн хэмжээнд түүврээр 7,689 өрхийг амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамруулан, өрхийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэсэн. Тус нэгдсэн сан дахь мэдээлэлд үндэслэн өрхийг амьжиргааны түвшнээр 5 бүлэгт хувааж, амьжиргааны түвшин доогуур айл өрхийн гишүүдэд журамд заасан хэмжээгээр¹¹ хүнсний эрхийн бичиг олгож байна.

Дүрслэл 4 Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан нийт өрхийн тоог амьжиргааны түвшний бүлгээр харуулсан харьцуулалт /Эх сурвалж ХХҮГ/



Аймгийн хэмжээнд 2019-2021 онд 1448 өрхийн 7643 хүнд 1,320.8 сая төгрөгийн хүнсний дэмжлэг үзүүлсэн байна.

Хүснэгт 8 Хүнсний эрхийн бичиг авсан өрхийн тоо, төсөв, гүйцэтгэл

№	Нийт өрхийн тоо	Хүнсний эрхийн бичиг авсан өрхийн тоо		Төсөв /сая төгрөг/	
		Өрхийн тоо	Хүний тоо	Батлагдсан	Гүйцэтгэл
2019	9980	534	2842	468.0	429.9
2020	9980	568	3040	439.5	682.3
2021.06.30	9980	561	2878	420.0	208.7

¹¹ Өрхийн амьжиргааны түвшин доогуур айл өрхийн 0-16 хүртэлх насны гишүүнд 8,000 төгрөг, 16-аас дээш насны гишүүнд 16,000 төгрөгийн хүнсний эрхийн бичиг авах журмын зохицуулалттай байна.

Аудитаар нэг хүний хоногт авбал зохих илчлэг, шим тэжээлийг¹² авахад шаардлагатай хүнсний бүтээгдэхүүний өртгийг¹³ тооцоход сарын өртөг нь үнийн түвшин хамгийн бага байх үед 197,750.00 төгрөг, дундаж үнээр тооцоход 293,283.00 төгрөг, хамгийн их байх үед 342,799.00 төгрөг болж байгаа бөгөөд энэ нь хүнс тэжээлийн дэмжлэгийн хэмжээнээс 12-21 дахин их байна.

Хэдийгээр өрхийн амьжиргааны түвшин доогуур өрхөд төрөөс хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж байгаа боловч дэмжлэгийн хэмжээ нь зарим өрхийн хувьд хоногт авбал зохих илчлэг, шим тэжээлийг авах боломжгүй байдалтай байна.

Энэ нь хүнсний эрхийн бичгээс өөр орлогын эх үүсвэргүй өрхийн гишүүд хоногт авбал зохих хүнсний илчлэг, шим тэжээлийг авч чадахгүй байх эрсдэлийг бий болгож байна. Хүнсний эрхийн бичиг олгох өрхийн амьжиргааны түвшнийг тооцохдоо өрхийн орлогын түвшинд судалгаа хийдэггүй учир тухайн өрхүүд хүнсний тэжээлийн дэмжлэгээс өөр орлогын эх үүсвэртэй эсэхийг аудитаар судлах боломжгүй байлаа.

Иймд хүнсний эрхийн бичиг авах өрхийн амьжиргааны түвшнийг тооцохдоо өрхийн орлогын түвшнийг харгалзан үзэх, тухайн хүнс тэжээлийн дэмжлэгээс бусад орлогын хэмжээг тооцож, хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодисын хэмжээг авахад шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой хэмжээгээр хүнсний дэмжлэгийн дүнг шатлалтайгаар тогтоох шаардлагатай байна.

¹² Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74-ээр тушаалаар батлагдсан хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис аминдэм, эрдэс бодисын хэмжээг тооцоололд ашигласан

¹³ Аудитаар нэг хүний хоногт авбал зохих илчлэг, шим тэжээлийг авахад шаардлагатай хүнсний бүтээгдэхүүний өртгийг тооцоход 2019 оны 8-р сард 5,010.00 төгрөг, 2020 оны 1-р сард 5,900.00 төгрөг, 2021 оны 5-р сард 7,450.00 төгрөг, сарын өртөг нь 2019 оны 8-р сард 150,061.00 төгрөг, 2020 оны 1-р сард 172,712.00 төгрөг, 2021 оны 5-р сард 214,477.00 төгрөг болж байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой нэгдсэн удирдлага, арга зүй, чиглэлээр хангах байгууллага, зөвлөл, албан тушаалтан байхгүйгээс бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөлт болон байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоо муутай байна.
- Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа тодорхойгүйн улмаас тоон мэдээллийг цуглуулах, нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх, түүнд үндэслэн бодлого, төлөвлөлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажил хийгдэхгүй байна.
- Засгийн газраас стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг боловсруулж, батлуулаагүйгээс аймагт хүнсний бүтээгдэхүүний улирлын стратеги нөөц бүрдүүлэхгүй байна.
- Хүнсний аюулгүй байдлыг хэмжих гол үзүүлэлтүүдийн нэг болох өлсгөлөнгийн талаар Тогтвортой хөгжлийн зорилго 2-д /2030 он гэхэд өлсгөлөнг зогсоох/тусгасан боловч өлсгөлөнгийн үзүүлэлтийг тооцдоггүй, заавар аргачлал гараагүй байна.
- Хүнсний сүлжээний үе шатуудад хяналт шалгалт хийгдэж байгаа ч хэрэгжилт хангалтгүй, зөрчлүүд давтагдан гарсаар байна.
- Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, лабораторийн шинжилгээний дүн болон хүнсний бүтээгдэхүүнээс шалтгаалсан өвчлөлийн тоон мэдээлэлд үндэслэн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлохгүй байна.
- Зохион байгуулсан сургалтын үр дүнг тооцож, дүн шинжилгээ хийдэггүйгээс хүнсний бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, шим тэжээл, эрүүл зөв хооллолтын дадал бий болгох олон нийтэд чиглэсэн ажил үр дүн муутай байна.
- Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, өрхийн сарын дундаж орлогын түвшин бага, хүнс тэжээлийн дэмжлэг оновчгүй зэргээс өрхийн амьжиргааны түвшин доогуур эмзэг бүлгийн айл өрх хүнс тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй байна.
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хүрэлцээ хангамж нь Улаанбаатарын үйлдвэрлэл болон импортын хэмжээ, цаг уурын нөхцөл байдал, газар зүйн байршил, зэргээс ихээхэн хамааралтай байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

- Аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн бодлогын баримт бичигт хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгагдсан заалт хоорондын уялдаа холбоог хангуулах, тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоон, жил бүрийн хүрэх түвшин, хийгдэх ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт хийн, үр дүнг тооцон ажиллаж байх;
- Аймагт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хийгдэх ажлыг тодорхой болгож, аймгийн бодлогын баримт бичгүүдэд санхүүжилтийн эх үүсвэрийн хамт тусгах;
- Хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг нэгдсэн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, хууль, эрх зүй, бодлогын хэрэгжилтийг хангуулах ажлын хэсэг ажиллуулах;
- Органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих талаар аймгийн бодлогын баримт бичигт тусган, үйлдвэрлэл эрхлэгч нарт органик бүтээгдэхүүнд тавигддаг шаардлага, бүртгэлжүүлэлт болон баталгаажуулалтын ажил хэрхэн хийгддэг талаар таниулах, мөн олон нийтэд органик бүтээгдэхүүний ашиг тусын талаар мэдлэг олгох сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой аймагт тохиолдож болзошгүй олон нийтийг хамарсан хоол, хүнсний хордлого, халдварт өвчин, хүнсний хомсдол үүсэх болон бусад эрсдэлтэй асуудлуудыг тодорхойлон, түүнийг арилгах, урьдчилан сэргийлэх, тодорхой арга хэмжээнүүдийн талаар аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж ажиллах;
- Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд орон нутгийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаар бодитой ажлуудыг санхүүгийн эх үүсвэрийн хамт төлөвлөн, хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллах.

Эрүүл мэндийн газарт:

- Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн давтагдан гарч буй зөрчил, лабораторийн шинжилгээний дүн, хүнсний бүтээгдэхүүнээс шалтгаалж болох өвчлөлийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, түүнд үндэслэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаж байх



Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

ҮАГ-аар дамжуулан холбогдох яамдад стандарт, дүрэм журам аргачлал боловсруулах, өөрчлөлт оруулах саналыг уламжилж байна.

Үндэслэл 1:

Хүнсний аюулгүй байдлыг хангах гол үзүүлэлтүүдийн нэг болох стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэлтийн талаар хуульд тусгагдсан боловч түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам батлагдан гараагүй учир аймагт нөөцийг бүрдүүлэх ажил хийгдэхгүй байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 1-р бүлгийн 1.1.1-р хэсгээс харна уу/

Санал 1: Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг боловсруулж, батлуулах талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх;

Үндэслэл 2:

Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний нэг болох өндөгний стандарт 1977 онд MNS 0095: 77 техникийн шаардлагаар батлагдан гарсан боловч одоог хүртэл стандартыг шинэчлээгүй ба өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 1-р бүлгийн 1.1.2-р хэсгээс харна уу/

Санал 2: Өндөгний үндэсний стандартыг олон улсын стандарт, үндэсний үйлдвэрлэлийн онцлогт нийцүүлэн боловсруулан, баталж, дагаж мөрдүүлэх талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх;

Үндэслэл 3:

Хүнсний аюулгүй байдлыг хэмжих гол үзүүлэлтүүдийн нэг болох өлсгөлөнгийн талаар Тогтвортой хөгжлийн зорилго 2-д /2030 он гэхэд өлсгөлөнг зогсооно/ тусгасан боловч өлсгөлөнгийн үзүүлэлтийг тооцдоггүй, заавар аргачлал гараагүй байна. Тус зорилгын нэг шалгуур үзүүлэлт болох 0-5 хүртэлх насны хүүхдийн БЖИ-ийг тодорхойлох, үнэлэх аргачлал, журам гараагүй байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 2-р бүлгийн 2.2-р хэсгээс харна уу/

Санал 3:

Тогтвортой хөгжлийн зорилго 2-ын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, заавар журмыг олон улсад ашигладаг аргачлалын дагуу боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг нэгдсэн зохион байгуулалтайгаар хийж байх талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх; */Дэлхийн өлсгөлөнгийн индексийг тооцох аргачлалыг тайлангийн 1.1.2 дахь хэсэг, ДЭМБ-аас боловсруулсан 0-5 хүртэлх насны хүүхдийн БЖИ-ийг тооцох, үнэлэх загвар хүснэгтийг хавсралт 2-оос тус тус харна уу/*

Үндэслэл:4

Өрхийн амьжиргааны түвшин доогуур өрхөд төрөөс хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж байгаа боловч дэмжлэгийн хэмжээ нь зарим өрхийн хувьд хоногт авбал зохих илчлэг, шим тэжээлийг авах боломжгүй байдалтай байна.

Аудитаар нэг хүний хоногт авбал зохих илчлэг, шим тэжээлийг¹⁴ авахад шаардлагатай хүнсний бүтээгдэхүүний өртгийг тооцоход сарын өртөг нь хүнс тэжээлийн дэмжлэгийн хэмжээнээс 12-21 дахин их байна.

Энэ нь хүнсний эрхийн бичгээс өөр орлогын эх үүсвэргүй өрхийн гишүүд хоногт авбал зохих хүнсний илчлэг, шим тэжээлийг авч чадахгүй байх эрсдэлийг бий болгож байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн 1-р бүлгийн 1.1.1-р хэсгээс харна уу/

Санал:4

Хүнсний эрхийн бичиг авах өрхийн амьжиргааны түвшнийг тооцохдоо өрхийн орлогын түвшнийг харгалзан үзэх, тухайн хүнс тэжээлийн дэмжлэгээс бусад орлогын хэмжээг тооцож, хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодисын хэмжээг авахад шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой хэмжээгээр хүнсний дэмжлэгийн дүнг шатлалтайгаар тогтоох талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх.

Үндэслэл:5

Сумдад хүнсний сүлжээний үе шатуудад хяналт шалгалт хийх эрхтэй албан хаагч байхгүй. Сумдын хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтнүүд нь тогтвор суурьшилтай ажилладаггүй, ажлын туршлага, ажилласан хугацаа бага, аймгийн хэмжээнд тус ажлын байранд сул орон тоо их байна. Энэ нь суманд хүнс, хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой ажлууд хийгдэхгүй орхигдох эрсдэлийг бий болгож байна. Хэдийгээр сумдад аймгийн МХГ-ын улсын байцаагч нар ажилладаг ч өдөр тутмын хяналт шалгалт хийх боломжгүйгээс сумдад хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалт, эрүүл ахуйтай холбоотой эрсдэлүүд бий болох, хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй байна. */Дэлгэрэнгүйг тайлангийн 1-р бүлгийн 1.3.4-р хэсгээс харна уу/*

Санал 5:

Сумдын хүнс, хөдөө аж ахуй хариуцсан албан тушаалтныг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хүнсний сүлжээний бүх үе шатад хяналт тавих эрх, үүргийг холбогдох хуулиар олгож, хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулах талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх.

¹⁴ Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74-ээр тушаалаар батлагдсан хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис аминдэм, эрдэс бодисын хэмжээг тооцоололд ашигласан

Үндэслэл:6 Монгол Улсын хууль, үндэсний стандартад хүнсний бүтээгдэхүүний зарим үзүүлэлтүүдийг тооцож байхаар заасан боловч тоног төхөөрөмжийн дутагдалтай байдлаас шалтгаалан ундны усны аюулгүйн үзүүлэлт, макро, микро элемент, хүнд металл илрүүлэх шинжилгээ ба шим тэжээлийн үзүүлэлтээс уургийн хэмжээ, транс тос илрүүлэх, хүнсний ногоонд пестицидийн үлдэгдэл тодорхойлох, гений өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг шинжлэх лабораторийн тоног төхөөрөмжгүй байна. */Дэлгэрэнгүйг тайлангийн 1-р бүлгийн 1.3.2-р хэсгээс харна уу/*

Санал 6: Дутагдалтай байгаа лабораторийн тоног төхөөрөмжийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх тухай зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх. */Дутагдалтай байгаа тоног төхөөрөмжийн жагсаалтыг хавсралт 4-өөс харна уу /*



Санал, тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж санал тайлбарыг авлаа.


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас/факс: 70592494
Цахим хаяг: info@dundgovi.gov.mn

2021. 11. 08 № 4/1546
танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дундговь аймгийн “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлантай холбоотой санал тайлбар байхгүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Н.ЭРДЭНЭ-ОЧИР



488211148

Хавсралт №1

“ДУНДГОВЬ АЙМГИЙГ 2018-2028 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХЭТИЙН ЗОРИЛТ”-ЫГ “АЙМГИЙН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДСАН БАЙДАЛ

2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт					2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		
Салбар	Зорилт	Заалт	Арга хэмжээ	Суурь түвшин /2017 он /	Төлөвлөсөн түвшин /2020 он/	Нийцсэн	Арга хэмжээ
Эрүүл мэнд	3.2.6	III.2.6.3.	Хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн тандалт судалгаа хийж, иргэдийн эрүүл амьдралын баталгааг сайжруулах	65	95		
		III.2.6.3.1.	Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд хийх хяналт шалгалтыг тогтмолжуулах	63	123		
		III.2.6.3.2.	Хүний эрүүл мэндэд хохирол учруулж байгаа гений өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнийг хориглох	0	70		
				0	1		
		III.2.6.3.3.	Иргэдэд эрүүл, зөв хооллолтын дадал хандлагыг хэвшүүлэх	2570	3700	2.4.1	Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх
	3.3	3.3.5	Эх хүүхдийн хоол тэжээлийн дутагдлыг бууруулна.	46.8 57.3	82.1 66.5		
Үйлдвэрлэл, үйлчилгээний салбар	Зорилт 1	4.1.1.7	Төмс хүнсний ногоо хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэн, хадгалах хугацааг уртасгах Сайнцагаан, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэлгэрхангай сумдад боловсруулах, нөөшлөх үйлдвэр байгуулах	0	1	8.3.2.1	Төмс хүнсний ногоо, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэн хадгалах хугацааг уртасгах боловсруулах, нөөшлөх үйлдвэрийг байгуулна
		4.1.3.4	Сайхан-Овоо суманд усалгаатай газар тариалангийн /төмс хүнсний ногоо чацаргана/	7.7	7.8	8.3.2.2	Сайхан-Овоо суманд Онги голын ус хуримтлуулах болон гүн

			талбайн хэмжээг нэмэгдүүлэх, хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх	47.3	50		өрмийн худаг барьж усалгаатай тариалалтыг нэмэгдүүлнэ
	Зорилт 2	4.2.1	Өндөр ашиг шимт мах сүүний чиглэлийн үхрийн аж ахуй байгуулах, эрчимжсэн аж ахуй эрхлэх сонирхолтой иргэдийн судалгааг гаргаж арга зүйн зөвлөгөө өгөх	458	800		
	Зорилт 4	4.4.4	Сайнцагаан, Эрдэнэдалай сумдад хүн амын хүнсний хэрэгцээний 60-с доошгүй хувийг хангах хүнсний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулах	4	5		
				105	130		
		4.4.5	Өлзийт, өндөршил сумдад ингэний сүү сүүн бүтээгдэхүүн ноосны анхан шатны үйлдвэр байгуулж ашиглалтад оруулах	0	1	8.3.1.4	Өлзийт суманд ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулж ингэний сүүний үнэлэмжийг нэмэгдүүлнэ
				0	20		
		4.4.6	Эрүүл ахуйн стандартад нийцсэн мал нядалгааны цехийг бүх сумдад байгуулж ашиглалтад оруулах	1	5	8.3.1.3	МАН-н гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, уламжлалт болон дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. /мах, ноос, ноолуур, арьс шир, сүү сүүн бүтээгдэхүүн.../

Хавсралт №2

**ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ГАРГАСАН 0-5 НАСНЫ
ЭРЭГТЭЙ ХҮҮХДИЙН БИЕЙН ЖИНГИЙН ИНДЕКСИЙН СУДАЛГАА**

Жил	Сар	-3СХ	-2СХ	-1СХ	Z оноо дундаж	1СХ	2СХ	3СХ
0:00	0	12.9	11.1	12.2	13.4	14.8	16.3	18.1
0:01	1	12.8	12.4	13.6	14.9	16.3	17.8	19.4
0:02	2	12.8	13.7	15	16.3	17.8	19.4	21.1
0:03	3	12.7	14.3	15.5	16.9	18.4	20	21.8
0:04	4	12.7	14.5	15.8	17.2	18.7	20.3	22.1
0:05	5	12.7	14.7	15.9	17.3	18.8	20.5	22.3
0:06	6	12.6	14.7	16	17.3	18.8	20.5	22.3
0:07	7	12.6	14.8	16	17.3	18.8	20.5	22.3
0:08	8	12.5	14.7	15.9	17.3	18.7	20.4	22.2
0:09	9	12.5	14.7	15.8	17.2	18.6	20.3	22.1
0:10	10	12.5	14.6	15.7	17	18.5	20.1	22
0:11	11	12.4	14.5	15.6	16.9	18.4	20	21.8
1:00	12	12.4	14.4	15.5	16.8	18.2	19.8	21.6
1:01	13	12.4	14.3	15.4	16.7	18.1	19.7	21.5
1:02	14	12.3	14.2	15.3	16.6	18	19.5	21.3
1:03	15	12.3	14.1	15.2	16.4	17.8	19.4	21.2
1:04	16	12.3	14	15.1	16.3	17.7	19.3	21
1:05	17	12.2	13.9	15	16.2	17.6	19.1	20.9
1:06	18	12.2	13.9	14.9	16.1	17.5	19	20.8
1:07	19	12.2	13.8	14.9	16.1	17.4	18.9	20.7
1:08	20	12.2	13.7	14.8	16	17.3	18.8	20.6
1:09	21	12.2	13.7	14.7	15.9	17.2	18.7	20.5
1:10	22	12.1	13.6	14.7	15.8	17.2	18.7	20.4
1:11	23	12.1	13.6	14.6	15.8	17.1	18.6	20.3
2:00	24 ¹	12.1	13.6	14.6	15.7	17	18.5	20.3
2:00	24	12.1	13.8	14.8	16	17.3	18.9	20.6
2:01	25	12.1	13.8	14.8	16	17.3	18.8	20.5
2:02	26	12.1	13.7	14.8	15.9	17.3	18.8	20.5
2:03	27	12.7	13.7	14.7	15.9	17.2	18.7	20.4
2:04	28	12.7	13.6	14.7	15.9	17.2	18.7	20.4
2:05	29	12.7	13.6	14.7	15.8	17.1	18.6	20.3
2:06	30	12.6	13.6	14.6	15.8	17.1	18.6	20.2
2:07	31	12.6	13.5	14.6	15.8	17.1	18.5	20.2
2:08	32	12.5	13.5	14.6	15.7	17	18.5	20.1
2:09	33	12.5	13.5	14.5	15.7	17	18.5	20.1
2:10	34	12.5	13.4	14.5	15.7	17	18.4	20
2:11	35	12.4	13.4	14.5	15.6	16.9	18.4	20
3:00	36	12.4	13.4	14.4	15.6	16.9	18.4	20

3:01	37	12.4	13.3	14.4	15.6	16.9	18.3	19.9
3:02	38	12.3	13.3	14.4	15.5	16.8	18.3	19.9
3:03	39	12.3	13.3	14.3	15.5	16.8	18.3	19.9
3:04	40	12.3	13.2	14.3	15.5	16.8	18.2	19.9
3:05	41	12.2	13.2	14.3	15.5	16.8	18.2	19.9
3:06	42	12.2	13.2	14.3	15.4	16.8	18.2	19.8
3:07	43	12.2	13.2	14.2	15.4	16.7	18.2	19.8
3:08	44	12.2	13.1	14.2	15.4	16.7	18.2	19.8
3:09	45	12.2	13.1	14.2	15.4	16.7	18.2	19.8
3:10	46	12.1	13.1	14.2	15.4	16.7	18.2	19.8
3:11	47	12.1	13.1	14.2	15.3	16.7	18.2	19.9
4:00	48	12.1	13.1	14.1	15.3	16.7	18.2	19.9
4:01	49	12.1	13	14.1	15.3	16.7	18.2	19.9
4:02	50	12.1	13	14.1	15.3	16.7	18.2	19.9
4:03	51	12.1	13	14.1	15.3	16.6	18.2	19.9
4:04	52	13	14.1	14.1	15.3	16.6	18.2	19.9
4:05	53	13	14.1	14.1	15.3	16.6	18.2	20
4:06	54	13	14	14	15.3	16.6	18.2	20
4:07	55	13	14	14	15.2	16.6	18.2	20
4:08	56	12.9	14	14	15.2	16.6	18.2	20.1
4:09	57	12.9	14	14	15.2	16.6	18.2	20.1
4:10	58	12.9	14	14	15.2	16.6	18.3	20.2
4:11	59	12.9	14	14	15.2	16.6	18.3	20.2
5:00	60	12.9	14	14	15.2	16.6	18.3	20.3

Хавсралт №2

**ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ГАРГАСАН 0-5 НАСНЫ
ЭМЭГТЭЙ ХҮҮХДИЙН БИЕЙН ЖИНГИЙН ИНДЕКСИЙН СУДАЛГАА**

Жил	Сар	-3СХ	-2СХ	-1СХ	Z оноо дундж	1СХ	2СХ	3СХ
0:00	0	10.1	11.1	12.2	13.3	14.6	16.1	17.7
0:01	1	10.8	12	13.2	14.6	16	17.5	19.1
0:02	2	11.8	13	14.3	15.8	17.3	19	20.7
0:03	3	12.4	13.6	14.9	16.4	17.9	19.7	21.5
0:04	4	12.7	13.9	15.2	16.7	18.3	20	22
0:05	5	12.9	14.1	15.4	16.8	18.4	20.2	22.2
0:06	6	13	14.1	15.5	16.9	18.5	20.3	22.3
0:07	7	13	14.2	15.5	16.9	18.5	20.3	22.3
0:08	8	13	14.1	15.4	16.8	18.4	20.2	22.2
0:09	9	12.9	14.1	15.3	16.7	18.3	20.1	22.1
0:10	10	12.9	14	15.2	16.6	18.2	19.9	21.9
0:11	11	12.8	13.9	15.1	16.5	18	19.8	21.8
1:00	12	12.7	13.8	15	16.4	17.9	19.6	21.6
1:01	13	12.6	13.7	14.9	16.2	17.7	19.5	21.4
1:02	14	12.6	13.6	14.8	16.1	17.6	19.3	21.3
1:03	15	12.5	13.5	14.7	16	17.5	19.2	21.1
1:04	16	12.4	13.5	14.6	15.9	17.4	19.1	21
1:05	17	12.4	13.4	14.5	15.8	17.3	18.9	20.9
1:06	18	12.3	13.3	14.4	15.7	17.2	18.8	20.8
1:07	19	12.3	13.3	14.4	15.7	17.1	18.8	20.7
1:08	20	12.2	13.2	14.3	15.6	17	18.7	20.6
1:09	21	12.2	13.2	14.3	15.5	17	18.6	20.5
1:10	22	12.2	13.1	14.2	15.5	16.9	18.5	20.4
1:11	23	12.2	13.1	14.2	15.4	16.9	18.5	20.4
2:00	24 ¹	12.1	13.1	14.2	15.4	16.8	18.4	20.3
2:00	24	13.3	13.3	14.4	15.7	17.1	18.7	18.7
2:01	25	13.3	13.3	14.4	15.7	17.1	18.7	18.7
2:02	26	13.3	13.3	14.4	15.6	17	18.7	18.7
2:03	27	13.3	13.3	14.4	15.6	17	18.6	18.6
2:04	28	13.3	13.3	14.3	15.6	17	18.6	18.6
2:05	29	13.2	13.2	14.3	15.6	17	18.6	18.6
2:06	30	13.2	13.2	14.3	15.5	16.9	18.5	18.5
2:07	31	13.2	13.2	14.3	15.5	16.9	18.5	18.5
2:08	32	13.2	13.2	14.3	15.5	16.9	18.5	18.5
2:09	33	13.1	13.1	14.2	15.5	16.9	18.5	18.5
2:10	34	13.1	13.1	14.2	15.4	16.8	18.5	18.5
2:11	35	13.1	13.1	14.2	15.4	16.8	18.4	18.4
3:00	36	13.1	13.1	14.2	15.4	16.8	18.4	18.4
3:01	37	13.1	13.1	14.1	15.4	16.8	18.4	18.4
3:02	38	13	13	14.1	15.4	16.8	18.4	18.4

3:03	39	13	13	14.1	15.3	16.8	18.4	18.4
3:04	40	13	13	14.1	15.3	16.8	18.4	18.4
3:05	41	13	13	14.1	15.3	16.8	18.4	18.4
3:06	42	12.9	12.9	14	15.3	16.8	18.4	18.4
3:07	43	12.9	12.9	14	15.3	16.8	18.4	18.4
3:08	44	12.9	12.9	14	15.3	16.8	18.5	18.5
3:09	45	12.9	12.9	14	15.3	16.8	18.5	18.5
3:10	46	12.9	12.9	14	15.3	16.8	18.5	18.5
3:11	47	12.8	12.8	14	15.3	16.8	18.5	18.5
4:00	48	12.8	12.8	14	15.3	16.8	18.5	18.5
4:01	49	12.8	12.8	13.9	15.3	16.8	18.5	18.5
4:02	50	12.8	12.8	13.9	15.3	16.8	18.6	18.6
4:03	51	12.8	12.8	13.9	15.3	16.8	18.6	18.6
4:04	52	13.9	13.9	15.2	16.8	18.6	18.6	20.7
4:05	53	13.9	13.9	15.3	16.8	18.6	18.6	20.8
4:06	54	13.9	13.9	15.3	16.8	18.7	18.7	20.8
4:07	55	13.9	13.9	15.3	16.8	18.7	18.7	20.9
4:08	56	13.9	13.9	15.3	16.8	18.7	18.7	20.9
4:09	57	13.9	13.9	15.3	16.9	18.7	18.7	21
4:10	58	13.9	13.9	15.3	16.9	18.8	18.8	21
4:11	59	13.9	13.9	15.3	16.9	18.8	18.8	21
5:00	60	13.9	13.9	15.3	16.9	18.8	18.8	21.1

Хавсралт №3

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЛАБОРАТОРИД ШИНЖЛҮҮЛСЭН УНДНЫ УСНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

Шинжилсэ н үзүүлэлтий н нэр, хэмжих нэгж	Ундны ус шүүсэн		Ундны ус шүүгээгүй		Цэвэр усны үйлдвэр	
	Шаардлаг а	Шинжилгээни й дүн	Шаардлаг а	Шинжилгээни й дүн	Шаардлаг а	Шинжилгээни й дүн
Аммони	1.5 мг/л- ээс ихгүй	0.0 мг/л	1.5 мг/л- ээс ихгүй	0.0 мг/л	илрэхгүй	илрэхгүй
Кальци	100 мг/л- ээс ихгүй	46.6 мг/л	100 мг/л- ээс ихгүй	46.4 мг/л	20 мг/л- ээс ихгүй	1.3 мг/л
Магни	30 мг/л- ээс ихгүй	25.5 мг/л	30 мг/л- ээс ихгүй	24.5 мг/л	5 мг/л-ээс ихгүй	1.2 мг/л
Нийт төмөр	0.3 мг/л- ээс ихгүй	0.0 мг/л	0.3 мг/л- ээс ихгүй	0.0 мг/л	0.2 мг/л- ээс ихгүй	0.0 мг/л
Нитрат	50 мг/л- ээс ихгүй	0.2 мг/л	50 мг/л- ээс ихгүй	0.2 мг/л	1.5 мг/л- ээс ихгүй	0.1 мг/л
Нитрит	1 мг/л-ээс ихгүй	0.0 мг/л	1 мг/л-ээс ихгүй	0.0 мг/л	илрэхгүй	илрэхгүй
pH	6.5-8.5	7.8	6.5-8.5	7.8	5.5-7.5	7
Сульфат	500 мг/л- ээс ихгүй	258.7 мг/л	500 мг/л- ээс ихгүй	254.3 мг/л	15 мг/л- ээс ихгүй	3 мг/л
Фтор	0.7-1.5 мг/л	1.1 мг/л	0.7-1.5 мг/л	1.1 мг/л		1.1 мг/л
Хатуулаг	7 мг- экв/л-ээс ихгүй	4.5 мг-экв/л	7 мг- экв/л-ээс ихгүй	4.4 мг-экв/л	1 мг- экв/л-ээс ихгүй	0.2 мг-экв/л
Хлорид	350 мг/л- ээс ихгүй	66.8 мг/л	350 мг/л- ээс ихгүй	66.8 мг/л	15 мг/л- ээс ихгүй	10.6 мг/л

Хавсралт №4

АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ СУДАЛГАА

№	Засварлах шаардлагатай					Шинээр авах шаардлагатай				
	Лабораторийн тоног төхөөрөмж		Жилд хийгдсэн шинжилгээний тоо		Тайлбар	Лабораторийн тоног төхөөрөмж		Хүчин чадал	Үнэ /сая.төг/	Хаана хандсан
			2019 он	2020 он						
1	Термостат /ТС-80М-2/	Гадаад орчин	135	107	температурын тохиргоо алдагдсан.	Микроскоп	Нян судлалын бүх төрлийн шинжилгээнээс илэрсэн бактерийг ялган таних	1000	3.60	Байгууллага, орон нутгийн хөгжлийн сан
2	Анерастат	агааргүйтэн нн үржүүлэх багаж	38	50	таганд цав суусан.	Термостат	Гадаад орчны шинжилгээнд +42 ⁰ С тохируулан хэрэглэх	200	2.50	-
3	Микроскоп /44345/	нян өсгөж харах багаж			Камер ажиллахгүй	Автоклав	Устгалын лаборатори	1000	14	
4	Автоклав /DAC-45/	ариутгалын лаборатори	878	889	Тагны резин жийргэвч тасарч муудсан.	Кьеалдалийн төхөөрөмж	Бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарыг тодорхойлох .	350	9	Байгууллага, орон нутгийн хөгжлийн сан
5	Автоклав /DZ-10 L/	Устгалын лаборатори	878	889	Даралтын хавхлаг гацдаг.	Кьеалдалийн дээж бэлтгэх зуух	шинжилгээ дээж бэлтгэх зуух .	350	4.7	Байгууллага, орон нутгийн хөгжлийн сан
6						Пестицидийн үлдэгдэл тодорхойлох багаж.	Жимс, хүнсний ногоонд пестицидийн үлдэгдэл тодорхойлно.	200	15	Байгууллага, орон нутгийн хөгжлийн сан
7						Testo 270 хоол тосны чанар шалгагч	тосны чанар шалгана.	250	10	Байгууллага, орон нутгийн хөгжлийн сан

Хавсралт №5

**ХҮНСНИЙ ЗОРИУЛАЛТЫН БУС ХУВАНЦАР САВ ХЭРЭГЛЭДЭГ ӨРХИЙН СУДАЛГАА
/2019 ОН/**

№	Сумын нэр	Нийт өрхийн тоо /2019 он/	Зориулалтын бус сав	Зориулалтын сав	Төвлөрсөн сүлжээнд холбогдсон
1	Сайнцагаан	4734	1847	1607	1280
2	Адаацаг	794	294	500	
3	Баянжаргалан	454	245	209	
4	Говь-Угтаал	496	199	297	
5	Гурвансайхан	658	152	479	27
6	Дэлгэрхангай	671	380	291	
7	Дэлгэрцогт	561	440	121	
8	Дэрэн	608	183	425	
9	Луус	562	439	123	
10	Өлзийт	752	415	275	62
11	Өндөршил	466	292	174	
12	Сайхан-Овоо	660	484	176	
13	Хулд	717	234	483	
14	Цагаандэлгэр	398	254	144	
15	Эрдэнэдалай	1663	1304	359	
Нийт		14194	7162	5663	1369

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг

баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39

E-mail: dundgovi@audit.gov.mn ОН